



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 12 сарыг 05 өдөр

Дугаар А/539

Мандалговь

Гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийг
хаягжуулах ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Хаягжуулалтын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Засгийн газрын 2013 оны 280 дугаар тогтоолоор батлагдсан "Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн, аж ахуй нэгж, байгууллагад шинээр эзэмшил, өмчлөл, ашиглалтаар олгож буй газруудыг Хаягжуулалтын тухай хуулийн дагуу хаягжуулах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Ж.Өлзийжаргал) нарт үүрэг болгосугай.

2. Хаягийн мэдээллийн сан үүсэхээс өмнөх эрх зүйн харилцаа үүссэн нэгж талбар, үл хөдлөх эд хөрөнгөд эрх бүхий байгууллагын олгосон хаягийг албан тодорхойлолтын дагуу улсын бүртгэлд бүртгэхдээ хаягийн мэдээллийг өөрчлөн бүртгэхийг Улсын бүртгэлийн хэлтэс (Ж.Өлзийжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010653

